

БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Өлгий сумын ЗДТГ
2017 оны 12 дугаар сарын 31-нээр
дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн тайлан

Аудитын код: БӨА-2018/18/СТА-ТШЗ

2018 оны 2 дугаар сар

ӨЛГИЙ СУМЫН ЗДТГ-ЫН 2017 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН



Нэмэлт мэдээлэл авахыг хүсвэл
дараах хаягаар харилцана уу:

Баян-Өлгий аймгийн
Аудитын газар

Тэргүүлэх аудитор
М.Хуанган
Утас:70422954

Аудитын менежер:
Х.Женисбек
Утас: 70422930

Аудитор: Д.Назгүл
99427301

Аудитын тайлан

Хавсралт 1: Агуулга

Хавсралт 2: Аудитын гэрчилгээ

Хавсралт 3: Менежментийн захидал

Хавсралт 4: Аудит хийсэн санхүүгийн тайлан

Хавсралт 5: Төсвийн гүйцэтгэлийн тайлан

Хаяг: Баян-Өлгий аймаг дахь
Төрийн аудитын газар

Байршил: Өлгий сум, 5-р баг,
Аймгийн ЗДТГазрын байр, 1-р
давхар

Цахим хуудас: www.bayan-ulqii.gov.mn

2018 оны 2 дугаар сар

АГУУЛГА

1. Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл
2. Байгууллагын хууль, эрх зүйн орчин
3. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа
4. Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн
5. Дотоод хяналт
6. Төсвийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар
7. Шилэн дансны мэдээлэл
8. Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар
9. Гол, онцлог гүйлгээний талаарх (тохиромжтой бол) тайлбар
10. Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар:
11. Материаллаг бус залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар:
12. Анхаарал татахуйц бусад чухал асуудал
13. Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд
14. Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл
15. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт
16. Зөвлөмж
17. Аудитын гэрчилгээний тохирох загварын талаарх дүгнэлт

Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл:

Төсвийн тухай хуулийн 8.9.1, Төрийн аудитын тухай хуулийн 15.2.1 дэх заалтыг үндэслэн Төрийн аудитын тухай хуулийн 18.2-т заасан аймаг дах Төрийн аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд Өлгий сумын ЗДТГ-ын 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийлээ.

Аудитыг Төсвийн тухай, Төрийн аудитын тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын олон улсын стандартын зарчмуудад нийцүүлэн төлөвлөлтийн шатанд боловсруулсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Өлгий сумын ЗДТГ-ын 2017 оны санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн Олон улсын стандарт /УСНББОУС/, түүнд нийцүүлэн гаргасан улсын төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн захирагч санхүүгийн тайлангаа УСНББОУС, түүнд нийцүүлсэн Сангийн сайдын холбогдох журмууд, төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, програм хангамжийн дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Тухайн санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС-тай нийцүүлж материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Өлгий сумын ЗДТГ-ын 2017 оны санхүүгийн тайлангийн аудитыг 2018 оны 1 дүгээр сарын 25-наас 2018 оны 2 дугаар сарын 25-ны хооронд хийхээр төлөвлөн хэрэгжүүлэв. /ТАБ-СТА-А-9/

Өлгий сумын ЗДТГ-ын 2017 оны санхүүгийн тайланг 2018 оны 1 дүгээр сарын 25-нд Аймгийн Аудитын газарт ирүүлсэн байна.

Аймгийн Аудитын газар аудитыг 2018 оны 2 дугаар сарын 23-наас 2018 оны 2 дугаар сарын 25-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2018 оны 2 дугаар сарын 25-нд Өлгий сумын ЗДТГ-ын удирдлагад гардуулна.

Байгууллагын хууль, эрх зүйн орчин:

Өлгий сумын ЗДТГ-ын төсвийн захирагч нь Монгол улсын Төсвийн тухай, ЗЗНДНТУТХууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиудын хүрээнд үйл ажиллагаа явуулж байна. Тайлант онд тухайн байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг гол хууль, тогтоомж, түүнд нийцүүлэн гарсан журам, зааварт өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын зорилго, үйл ажиллагаа:

“Улс төрийн аливаа үзэл сурталд автахгүй төрийн ажлын чиг үүргийг гүйцэтгэн сумын засаг даргын үйл ажиллагааг үр дүнтэй тасралтгүй жигд нөхцөлөөр хангах замаар төрийн үйлчилгээг ард иргэдэд ил тод, хүртээмжтэй шуурхай хүргэж иргэдийн ажиллах амьдрах таатай нөхцөлийг бүрдүүлнэ.” гэж байгууллагын үйл ажиллагааны зорилтыг тодорхойлсон байна.

Дээрх зорилтыг хэрэгжүүлэхийн тулд Монгол Улсын Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1-д “Төсвийн байгууллага нь түүний үйл ажиллагааг үр ашигтай удирдлагаар хангаж, ажлын үр дүнг хариуцах үүрэг бүхий төсвийн шууд захирагчтай байна” гэж заасан байна.

Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 4.18-д “төсвийн бусад байгууллагын дарга (захирал, эрхлэгч) тухайн байгууллагын төсвийн төсвийн шууд захирагч байна” гэж заасны дагуу Өлгий сумын ЗДТГ-ын дарга Төсвийн захирагчийн үүргийг гүйцэтгэж байна. Өлгий сумын ЗДТГ-ын 2017 оны төсвийг аймгийн ТЕЗ-ийн төсвийн багцаас аймгийн төрийн сангаар дамжуулан Өлгий сумын төрийн сангаас олгож байна.

Төсвийн шууд захирагчтай холбоотой хууль эрх зүйн баримт бичгийг судалсан бөгөөд байгууллагатай холбоотой Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, ЗЗНДНТУТХууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулиудыг хэрэгжүүлэн ажиллаж байна.

Өлгий сумын ЗДТГ-ын үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд ТАБ-СТА-А-1 маягтад тодорхой тусгасан.

Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн:

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг шалгуур болгон ашиглав.

Аудитаар Өлгий сумын ЗДТГ-ын 2017 оны санхүүгийн тайланд дүгнэлт өгөх үүднээс төсвийн захирагчийн удирдлагын бэлтгэсэн санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд төсвийн дансдын уламжлалт эрсдэл болон хяналтын эрсдэлийг тогтоон тухайн байгууллагын зүгээс тавьж буй дотоод хяналтыг үнэлж баримтжууллаа. /ТАБ-СТА-А-5/

Санхүүгийн тайланг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, зарим гүйлгээ ихтэй томоохон дансдад түүвэрчилсэн байдлаар аудитын нарийвчилсан горим, сорил 14-ийг гүйцэтгэв. /ТАБ-СТА-В-3/

Тухайн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, системтэй танилцахад Өлгий сумын ЗДТГ-ын санхүүгийн үйл ажиллагаанд хэрэглэгдэх нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулан батлуулж мөрдөн ажиллаж байна. Энэхүү бүртгэлийн бодлогын баримт бичиг нь УСНББОУС-тай нийцсэн байна. ОУ-ын стандарттай нийцсэн бүртгэлийн бодлоготой, нягтлан бодох бүртгэлийн програм нийцсэн байна.

Өлгий сумын ЗДТГ-ын санхүүгийн үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа компьютерийн системийн үйл ажиллагаатай асуулга явуулах аргаар танилцан түүний нарийн төвөгтэй байдлын үнэлгээг хийхэд “бага” буюу мэдээллийн технологийн мэргэжилтэнг оролцуулах шаардлагагүй гэсэн үнэлгээ авсан тул аудитыг шууд гүйцэтгэлээ. /ТАБ-СТА-В-2/

Өлгий сумын ЗДТГ-ын санхүүгийн үйл ажиллагааг бүртгэх, хянах, боловсруулах үйл ажиллагааг санхүүгийн програмаар боловсруулан санхүүгийн тайлан бэлтгэх аргачлалын дагуу санхүүгийн тайланг гаргасан байна.

Дотоод хяналт:

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хийсэн. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалахын тулд жилийн турш үр нөлөөтэй ажиллах ёстой гол хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм. Татварын хэлтсийн дотоод хяналт эрсдэлийг төлөвлөлтийн үед “бага” гэж тооцсон ба дахин хянахад дотоод хяналт хэвийн байна.

Төсвийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар:

2017 оны батлагдсан төсвийг сар, улирлын хуваарийн дагуу аймгийн ТЭЗ-ийн төсвийн багцаас аймгийн төрийн сангийн харилцах дансаар дамжуулан Өлгий сумын төрийн сангаас санхүүжүүлснээс гадна төсвийн хүрээний мэдэгдлийг боловсруулах, төсвийн санхүүжилтийн гүйцэтгэлийг хангах, төсвийг зардлын төрөл зүйлээр хуваарилан гүйцэтгэлд хяналт тавин ажилласан байна.

Өлгий сумын ЗДТГ-ын төсвийн захирагч нь 2017 онд 571,8 сая төгрөгийн батлагдсан төсвөөр үйл ажиллагаа явуулж, улсын төсвөөс урсгал зардалд 571,8 сая төгрөгийн санхүүжилт авч зарцуулсан ба оны эхний мөнгөн хөрөнгийн үлдэгдлийг зарцуулсанаар 572,4 мянган төгрөгий гүйцэтгэлтэй байна. Нийт төсвийн 75,9 хувийг буюу 435,0 сая төгрөгийг ажиллагсадтай холбоотой зардал, 9,4 хувийг буюу 54,1 сая төгрөгийг урсгал шийлжүүлэг, 14,7 хувийг буюу 83,3 сая төгрөгийг бусад бараа үйлчилгээний зардал эзэлж байна.

Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн дагуу төсвийн хөрөнгийг үр ашигтай захиран зарцуулах зорилгоор төсвийн удирдлагын шийдвэр, үйл ажиллагаа ил тод, нээлттэй, ойлгомжтой байх, түүнд олон нийт хяналт тавих мэдээллийн тогтолцоог хуулийн дагуу хангаж ажиллах зорилгоор shilendans.gov.mn цахим хуудсанд 2017 оны мэдээлэлээ бүрэн байршуулжээ.

2017 онд Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэнд хийсэн нийцлийн 6.1.2, Шилэн дансны тухай хуулийн 6.1.3, 6.1.4, 6.1.5, 6.4.5 дахь заалтуудыг зөрчсөн 260,6 сая төгрөгийн алдаа зөрчилд албан шаардлага хүргүүлж биелэлтийг хангуулсан байна.

Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар:

Аудитын төлөвлөгөөний дагуу аудитын 23 эрсдлийг тогтоож, батламж мэдэгдлүүдийн хүрээнд данс бүрээр нийт 14 хяналтын болон нарийвчилсан горим, сорил гүйцэтгэв.

Үр дагаварыг тодорхойлж чадвал: Аудитаар алдаа зөрчил илэрсэн.

Гол, онцлог гүйлгээний талаарх (тохиромжтой бол) тайлбар:

Өлгий сумын ЗДТГ-ын 2017 оны санхүүгийн тайлан материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэдгийг, түүнийг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, аудитын явцад санхүүгийн тайланд нөлөөлөхүйц хэмжээний санхүүжилт, нэмэлт санхүүжилт, мөнгөн хөрөнгө, үндсэн хөрөнгө, цалин, түлш халаалт, орон нутгийн нөөц хөрөнгө, тээвэр шатахууны зардал, МЭҮЗардал зэрэг дансанд ажил гүйлгээ, үлдэгдэл, тооцооллуудыг түүвэрчлэн нарийвчилсан горим, сорилын аргаар шалгалаа. /ТАБ-СТА-В-3/

Эдгээр шалгасан нарийвчилсан сорил нь тус байгууллагын нийт орлого, мөнгөн хөрөнгийг 100 хувь, нийт зардлын 85,9 хувь, нийт хөрөнгийн 100 хувийг тус тус эзэлж байна.

Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар:

Материаллаг алдаа зөрчлүүд:

Санхүүгийн тайлангийн аудитаар хөндөгдсөн гол асуудлуудыг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв. Аудитын явцад материаллаг хэмжээний дараах алдаа илэрсэн байна. Үүнд:

1.Өмнөх оны ХХОАТ-ын 5,6 сая төгрөгийн өглөгийг санхүүгийн тайланд тусгаж харуулаагүй орхигдуулсаныг тайлант оны төсвөөс төлсөн.

Шийдвэрсэсэн: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1, 13.5, 13.6, 13.7, 14.3.1 дэхь заалтуудыг мөрдөж анхан

шатны баримтыг зохих журмын дагуу бүрдүүлж, нягтлан бодох бүртгэлийг холбогдох заавар, журам, стандартын дагуу үнэн зөв хөтлөх талаар албан шаардлага өгөв.

2. Түүвэрлэж үзсэн баримтуудаас нягтлан бодох бүртгэл хөтлөлттэй холбоотой цалингийн зардлаас 60,6 сая төгрөгийн, НДШ-ийн зардлаас 7,7 сая төгрөгийн, шатахууны зардлаас 0,9 сая төгрөгийн, халаалтын зардлаас 7,4 сая төгрөгийн, МЭАХ-ний зардлаас 0,9 сая төгрөгийн, төрөөс иргэдэд нэг удаа олгох тэтгэмжийн зардлаас 3,6 сая төгрөгийн, нэмэлт санхүүжилтийн дансаар 0,8 сая төгрөгийн буюу нийтдээ 27 ш 81,9 сая төгрөгийн ажил гүйлгээний анхан шатны баримтыг дутуу бүрдүүлсэнээс 10,2 сая төгрөгийн 2 ш цалингийн цэс байхгүй, 32,43 сая төгрөгийн 10ш гүйлгээний төлбөрийн хүсэлт байхгүй, байгууллагын тамгагүй, даргын гарын үсэггүй, нягтлан бодогчийн гарын үсэггүй, төлбөрийн хүсэлт дугааргүй, төрийн сангийн гүйлгээ хийсэн тамга, гарын үсэггүй зэрэг 17 ш баримтаар давхардсан тоогоор 49,5 сая төгрөгийн гүйлгээ хийгдсэн зөрчил илэрсэн.

Шийдвэрсэсэн: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1, 13.5, 13.6, 13.7, 14.3.1 дэхь заалтуудыг мөрдөж анхан шатны баримтыг зохих журмын дагуу бүрдүүлж, нягтлан бодох бүртгэлийг холбогдох заавар, журам, стандартын дагуу үнэн зөв хөтлөх талаар албан шаардлага өгөв.

Материаллаг бус алдаа зөрчлүүд

Материаллаг бус алдаа зөрчил илэрээгүй.

Залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар:

Залруулагдаагүй алдаа зөрчил байхгүй.

Анхаарал татахуйц бусад чухал асуудал:

Анхаарал татахуйц чухал асуудал үгүй байна.

Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд:

Өлгий сумын ЗДТГ-ын 2017 оны санхүүгийн тайлангийн аудитын явцад кассын тайланг холбогдох журмын дагуу үнэн зөв гаргаагүйтэй холбоотой үнэт цаасны гурвалжингийн орлогын зарцуулалтын баримтыг гүйцээж мөшгин шалгаж амжаагүй, эрсдэлтэй гарч болзошгүй юм.

Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл:

Өлгий сумын ЗДТГ-ын 2017 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 87,5 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрсэн.

Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт:

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар зөвлөмж өгөгдөөгүй байна.

Санал дүгнэлт

Өлгий сумын ЗДТГ-ын 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдээ холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн ба тус байгууллагыг түүвэрт хамруулж үзсэн тул Өлгий сумын ТТЗ-ийн НСТайлангаар нэг дүгнэлт гаргахаар болсон.

Аудитлагдсан санхүүгийн тайлан 8 хуудас, хавсралтууд хуудсыг тус тус хавсаргав.

АУДИТЫН ТАЙЛАНГ:

ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

М.ХУАНГАН

АУДИТЫН МЕНЕЖЕР

Х.ЖЕНИСБЕК

БЭЛТГЭСЭН: АУДИТОР

Д.НАЗГҮЛ
2018.02.25